

Япон хэлний өгөх, авах утгат туслах үйл үг -te morau хэллэгийн утга, хэрэглээний онцлог

Гао Улань 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн докторант, Хөх хотын үндэстний дээд сургууль, Хөх хот, Хятад улс

Найдангийн Баярмаа

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Дорно дахины хэлний тэнхимийн ахлах багш, доктор, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-03-22

Засварласан - Revised:
2024-04-12

Хэвлэгдсэн - Published:
2024-05-25

qingfengyaxugwlr@163.com

ORCID:[0009-0000-3437-2978](https://orcid.org/0009-0000-3437-2978)



© 2024, Author(s)

Хураангуй: Япон хэлэнд “-ж өгөх”, “-ж авах” хэмээх утга илэрхийлдэг -te morau туслах үйл үг нь яриа ба бичгийн хэлэнд утгын өргөн хүрээнд хэрэглэгддэг, олон хэрэглээтэй, хэлний орчны харилцан адилгүй нөхцөл байдлаас шалтгаалан хэл зүйн утга ч өөрчлөгддөг нь суралцагчдын хувьд сурах бэрхшээлүүдийн нэг болдог юм. Энэхүү өгүүлэлдээ хэлний материалын сангаас -te morau туслах үйл үг бүхий өгүүлбэрийг түүвэрлэн авч утга, хэрэглээнд дүн шинжилгээ хийхэд тустай (benefactive) болон тусгүй (non-benefactive) утгын илэрхийлэл гэсэн хоёр ангилалд хуваагдаж, мөн тус тус идэвхт байдал, идэвхгүй байдлын хэмээх утга агуулдаг болохыг олж мэдлээ.

Түлхүүр үг: утга, тустай, тусгүй утга, идэвхт, идэвхгүй байдал

УДИРТГАЛ

-te morau нь өгүүлбэрт ихэвчлэн “Yか³ (ga) X¹ (ni) Vte morau” хэлбэрээр хэрэглэгддэг. Y нь хүлээн авах эзэн бие буюу үйлдүүлэгч, X нь үйлийн эзэн бие буюу үйлдэгч, V нь хийсэн үйл буюу өгүүлбэрийн нийлмэл үйл өгүүлэхүүн бөгөөд энэ нь хүлээн авах эзэн бие буюу үйлдүүлэгч Y нь үйлийн эзэн бие буюу үйлдэгч X –ээс хүлээн авсан тусын илрэлийг илэрхийлдэг. Уламжлалт судалгааны ойлголтоос бол өгүүлэгдэхүүн, шууд бус тусагдахуунтай төстэй юм. Иймээс энэхүү судалгаандаа хүлээн авах эзэн бие, үйлийн эзэн бие хэмээн хэрэглэнэ.

Мацүшита, Д. (松下, 1930), Сүзүки, Ш. (鈴木, 1972), Ооэ, С. (大江, 1975), Масүока, Т. (益岡, 2001), Таками, К. Күно, С. (高見・久野, 2002) нарын судалгаанд тустай хэмээх утга санааг агуулсан илэрхийлэл нь -te morau хэллэгийн үндсэн хэрэглээ юм гэжээ. Энэ нь тухайн судалгааны Y эзэн биеийн үндсэн бус хэрэглээг анхаараагүйтэй холбоотой байх талтай.

Гэвч Ямамото, Х. (山本, 2003, х.269), Ямада, Т. (山田, 2004, х.153) нар -te morau-д элбэрэл ачлал буюу тустай хэмээх утгаас гадна тусгүй хэмээх утга ч ярианд агуулагддаг болохыг олж мэджээ. Тиймээс Ямада, Т. (山田, 2004, х.153) үйлийн эзэн биеийн хийсэн үйлийн улмаас хүлээн авах эзэн бие хохирсон, тус болоогүй хэмээх хэрэглээг “тусгүй байдлын -te morau” (非恩恵型テモラウ hi onkeigata te morau) хэмээн томъёолжээ.

Масүока, Т. (益岡, 2001, х.28-29) -te morau -гийн идэвхт чанарт (働きかけ性 hatarakikakesei) үндэслэн “Үйлдүүлэх хэлбэр бүхий -te morau (使役型てもらう) өгүүлбэр, “үйлдэгдэх хэлбэр бүхий

-te morau” (受動型てもう *juudougata te morau*) өгүүлбэр гэж хуваан, “үйлдүүлэх хэлбэр бүхий - te morau (使役型てもらう *shiekigata te morau*) өгүүлбэр нь тустай хэмээх утга санааг илүү их агуулдаг бол, харин “үйлдэгдэх хэлбэр бүхий -te morau” (受動型てもらう) өгүүлбэр нь тустай хэмээх утга тийм ч их биш гэжээ.

Эндээс дүгнэхэд, япон хэлний үйлийн өгөх, авах илэрхийллийн гол хэлбэрүүдийн нэг болох -te morau туслах үйл үгийн хэрэглээ нь олон төрлийн сэтгэлийн илэрхийллийг агуулдаг бөгөөд зөвхөн үйлийг өгч, авснаар тустай болох хэмээх утга агуулахаас гадна, тусгүй хэмээх утгыг ч илэрхийлдэг байна. Үүгээр ч зогсохгүй -te morau хэллэгт идэвхт байдлын болоод идэвхгүй байдлын хэрэглээ ч байдаг байна. Гэсэн хэдий ч япон хэлний сурах бичгүүдэд тусгүй хэмээх утгын илэрхийлэл бараг дурдагддаггүйгээс гадна -te morau хэллэгийн идэвхт болоод идэвхгүй байдлын талаарх тайлбар маш цөөн байдаг. Эдгээр хязгаарлагдмал байдал нь суралцагчдад -te morau -гийн утгыг ойлгоход бэрхшээлтэй болгох, өөрөөр хэлбэл, тухайн хэллэгийн утга, үүргийг үл ойлгох, буруугаар хэрэглэх шалтгаан болох магадлалтай. Тиймээс бид -te morau хэллэгийн өгүүлбэрт хэрэглэгдэх утгын онцлогийг тодруулж, үүргийг нь тодорхой болгох хэрэгтэй хэмээн үзэж, энэхүү судалгаандаа -te morau нь тустай болон тусгүй, идэвхт болон идэвхгүй байдал хэмээх утгатай гэсэн судлаачдын дүгнэлтэд үндэслэн япон эхэд дүн шинжилгээ хийлээ. Үүний үр дүнд -te morau хэллэгийг япон хэл суралцагчид эхээр дамжуулан ойлгох боломжтой болохын сацуу, багш нарт ч хичээл заахад хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

1. -te morau хэллэгтэй өгүүлбэрийн утга, хэрэглээний онцлогийн ангилал

Энэхүү судалгаандаа -te morau хэллэгийг судалгааны объект болгон, хэлний материалын сан “Shīdīromu-ban Shinchō bunko no 100-satsu” (『CD-ROM版新潮文庫の100冊』), “CD-Mainichishinbun dēta-ban” (『CD-毎日新聞データ版』) -аас -te morau өгүүлбэрийн жишээг түүсэн ба энэхүү өгүүлэлдээ -te morau хэллэгийн утгын онцлогийг харуулахын тулд 100 орчим өгүүлбэрийн утгыг тодорхойлж чадах 13 жишээ өгүүлбэрийг сонгож тустай болон тусгүй хэмээх утга, идэвхт болон идэвхгүй байдлын талаас ангилан дүн шинжилгээ хийлээ.

-te morau хэллэг бүхий өгүүлбэрийн хэрэглэгдэж буй байдал, утга, хэрэглээний онцлогийг тодруулахын тулд, энэхүү судалгаанд Мацүшита, Д. (松下, 1930), Сүзүки, Ш. (鈴木, 1972), Ооэ, С. (大江, 1975), Масүока, Т. (益岡, 2001) Таками, К. Күно, С. (高見・久野, 2002) нарын тодорхойлсон тустай хэмээх утгын илэрхийлэл, Яамото, Х. (山本, 2003), Яамада, Т. (山田, 2004) нарын тодорхойлсон тусгүй утгын илэрхийлэл гэсэн хоёр ангиллыг ашиглан энэхүү онцлог илрэх эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Мөн Масүока, Т. (益岡, 2001, х.28-29) -ийн тодорхойлсон -te morau -гийн идэвхт байдал, идэвхгүй байдлыг “үйлдүүлэх хэлбэр - te morau” (使役型てもらう) өгүүлбэр, “үйлдэгдэх хэлбэр -te morau” (受動型てもらう) өгүүлбэр гэж хуваасан судалгаанаас үзвэл -te morau хэллэгийн тустай болон тусгүй утгын илэрхийллийн аль аль нь идэвхт байдал, идэвхгүй байдлын утгыг илэрхийлж байлаа. Иймээс -te morau хэллэгийн идэвхт байдлыг тодорхой болгохын тулд хүлээн авах эзэн бие болон үйлийн эзэн бие нь оюун ухааны бодол зорилготойгоор хийсэн болон оюун ухааны бодол зорилгогүйгээр хийсэн үйлдэл хэмээн ангилах боломжтой хэмээх таамаг дэвшүүлэн судаллаа.

1.1. -te morau -гийн тустай хэмээх утга, хэрэглээний онцлог

-te morau нь ихэвчлэн “Yが (ga) Xに (ni) Vte morau” байдаг бүтэцтэй бөгөөд X нь Y- д тодорхой үйлдэл хийж, түүний үр дүнд Y нь тус хүртсэн утгыг илэрхийлдэг. Энэхүү судалгаанд хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед оюун ухааны бодол зорилготойгоор хийсэн үйл эсэхэд тулгуурлан -te morau хэллэгийг идэвхт байдал, идэвхгүй байдлын хэрэглээ хэмээн хувааж дүн шинжилгээ хийж үзлээ.

1.1.1. Идэвхт байдлын хэрэглээ

Идэвхт байдлын хэрэглээ гэдэг нь хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед тодорхой үйлийг хийхэд түлхэц үзүүлж тустай байх утгыг хэлнэ. Иймд хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед үйлийг хийх хүсэл эрмэлзлийг бий болгож, үйлийн эзэн биеийн хийсэн үйлийн үр дүнд хүлээн авах эзэн бие тус авсан хэмээх утга бүхий өгүүлбэр юм.

(1) いけない事に、私自身の生活が時たま完全に行きづまる事がしばしばあった。そんな時には、古本屋の顔なじみの親父さんに頼んで一定の期限をおいて買い取ってもらうのだった。

(五木寛之 『風に吹かれて』)

Харамсалтай нь миний амьдрал хааяадаа бүр зогсонги байдалд ордог байв. Тэр үед хуучин номын дэлгүүрийн танил өвгөнөөс гуйж хэсэг хугацаанд номоо тавьж заруулж авдаг байлаа.

(2) 独りで食えば、鼻の先が鉢の中の飯へとどいてしまう。そこで内供は弟子の一人を膳の向うへ坐らせて、飯を食う間中、広さ一寸長さ二尺ばかりの板で、鼻を持ち上げていて貰うことにした。

(芥川龍之介 『鼻』)

Өөрөө идвэл хамрын үзүүр будааны аяганд орчихно. Тиймээс Naigu зарц шавь нарынхаа нэгийг ширээнд суулгаж, хоол идэж байхдаа нэг инч өргөн, хоёр фут урттай банзаар хамраа өргүүлэхээр болов (үгчлэн орчуулбал: хамраа барьж өргүүлэн авдаг болгожээ.).

(3) 仕方がないので会社の事情を説明し、鉄道電話で石炭の今後の輸送事情を調べてもらうように、言葉をつくして駅長にも助役にも嘆願した。

(井伏鱒二 『黒い雨』)

Өөр арга байхгүй тул компанийн нөхцөл байдлыг тайлбарлаж, төмөр замын утсаар цаашдын нүүрс тээвэрлэлтийн нөхцөл байдлыг шалгаж өгөхийг станцын дарга болон түүний туслахаас хамгийн сайн үгээр гуйхаас өөр аргагүй болсон.

Энэхүү (1) - (3) өгүүлбэрийн утгаас үзвэл хүлээн авах эзэн биед үйлийн эзэн биеийн хийсэн үйл нь хүсэл эрмэлзлийг төрүүлж, үйлийн эзэн биеийн гүйцэтгэсэн үйлдлээс ашиг хүртсэн утга бүхий өгүүлбэр байна. Өгүүлбэр (1)-д хүлээн авах эзэн бие “би” нь үйлийн эзэн бие “хуучин номын дэлгүүрийн танил өвгөн”-өөс өөрийн номоо хуучин номын дэлгүүртээ тавихыг хүснэ. Энэ үйлдэл нь хүлээн авах эзэн биед ашигтай байх боломжийг олгох буюу тустай байдлыг илэрхийлж байна.

Өгүүлбэр (2) -г хүлээн авах эзэн бие болох “Naigu” нь урт хамартай тул хоол идэх үед хамар нь аяга руу ордог учир хоол идэхдээ “шавь” нараараа хамраа өргүүлэн байж сая нэг хоол иддэг байна. Иймээс “шавь” -ийн “хамар өргөж” буй үйлдэл нь “Naigu”-д өгч буй тустай үйл гэж үзэж болно. Өгүүлбэр (3)-ын хүлээн авах эзэн бие “би” нь “станцын дарга, туслах” -д “тээврийн нөхцөл байдал”

-ыг шалгаж өгөхийг хүснэ. Энэ “шалгах” үйлдэл нь хүлээн авах эзэн биед тус хүртэх боломжийг олгож байна.

1.1.2. Идэвхгүй байдлын хэрэглээ

Идэвхгүй байдлын хэрэглээ гэдэг нь хүлээн авах эзэн бие нь тухайн үйлийн эзэн биеийг тодорхой үйлийг гүйцэтгэхэд түлхэц үзүүлэхгүй, харин тухайн үйлийн эзэн биеийн боюу нэг талын үйлийн нөлөөнд автаж тус авахыг хэлнэ. Энэ төрлийн хэрэглээ нь хүлээн авах эзэн биеийн хүсэл зорилготой ямар ч холбоогүй, зөвхөн үйлийн эзэн бие үйлийг идэвхгүй байдлаар хүлээн авдаг.

1) Оюун ухааны бодолтой үйлийн эзэн бие бүхий өгүүлбэр

Хүлээн авах эзэн бие өөрийн идэвх санаачилгаар бус, үйлийн эзэн биеийн оюун ухааны бодол зорилготойгоор хийсэн үйлдлээс тустай болох хэмээх утга бүхий өгүүлбэр юм.

(4) 私は原稿を書くのに行きつると、よく編集室に泊まり込んだ。そのような場合にも、彼らの一人と一緒に泊まり込み、一枚、また一枚と書き上がる私の原稿を、待ちかねるようによんでくれた。私は彼ら三人に喜んでもらうためだけに書いているような気がさえる。

(沢木耕太郎 『一瞬の夏』)

Би зохиолоо бичиж байхдаа гагцхиаараа ихэвчлэн редакторын өрөөнд хонодог байв. Ийм үед ч тэдний хэн нэг нь надтай хамт хонож, нэг нэг хуудсаар бичиж дуусгаж буй миний зохиолыг хүлээж ядан уншдаг байлаа. Би тэр гурвыг л баярлуулах гэж (зөвхөн баярлуулж авахын төлөө) бичиж байгаа юм шиг санагддаг байлаа.

(5) 君と行ったあの小学校の校庭も、木々がすっかり大きくなっていて、十年の歳月を感じさせてくれたよ。あの桜の下で、四年生のころの事件を話し合ったり、すっかりにぎやかになった銀座や浅草をぶらついたり、いろいろとつき合ってもらってありがとう。

(三浦綾子 『塩狩峠』)

Чамтай хамт явдаг байсан бага сургуулийн хашааны модод ч бүр том ургаад 10 жил өнгөрснийг санагдуулж байна. Тэр моносны модон доор дөрөвдүгээр ангид байсан үеийнхээ явдлыг ярьж, улам хөл хөдөлгөөнтэй болсон Гинза, Асакусагаар зугаалан найзалж байгаад баярлалаа. (янз бүрээр харилцаж найзалж өгч байгаад баярлалаа.)

(4) (5) өгүүлбэрийн хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед тодорхой үйл хийх хүсэл эрмэлзэл байхгүй боловч үйлийн эзэн биеийн хийсэн үйлдлээс тустай байсан хэмээх утга илэрхийлж байна. (4) өгүүлбэрийн хүлээн авах эзэн бие, үйлийн эзэн бие “тэр гурав” бүтээлийг нь уншаад “баяр хөөр” мэдрэхийг гуйгаагүй, эсвэл найдаагүй, гэвч тэр гурван хүнийг “баярлуулах”-ын тулд хүлээн авах эзэн бие “би”-д нэгэн төрлийн ач тустай үйлдэл мэт ойлгогдож байна.

(5) өгүүлбэрт хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн бие болох “чи” -гээс хамт явахыг хүсээгүй, гэхдээ өгүүлбэрийн төгсгөлд байгаа хүлээн авах эзэн биеийн “баярлалаа” хэмээх хариулт нь үйлийн эзэн бие “чиний” хамт явсан нь үйлийг хүлээн авах эзэн бие “би”-д тустай байлаа хэмээх санаа агуулагдаж байна гэж дүгнэж болно.

2) Оюун ухааны бодол зорилгогүй үйлийн эзэн бие бүхий өгүүлбэр

Хүлээн авах эзэн биед үйлийн эзэн биеийн оюун ухааны бодол зорилгогүйгоор хийсэн үйлийн үр дүнд тус хүртэж буй өгүүлбэр юм.

(6) 不自由な主人は、赤信号なのに横断歩道を渡ろうとしたとき、盲導犬に吠えてもらいこと

なきをえた。

(高見・久野, 2002)

Харааны бэрхшээлтэй эзэн нь улаан гэрэл ассан байхад зам гарах гэхэд хөтөч нохой хуцаж аюулгүй гарав. (үгчлэн орчуулбал: хөтөч нохой хуцаж өгөх тусаар аюулыг зогсоолоо.)

(7) 米を無農薬で栽培するため、雑草や害虫をアイガモに食べてもらう。「アイガモ農法」に約15年前から取り組んでいる。

(2010.12.17 朝日新聞)

Будаг хортон шавж устгах бодисгүй ургуулахын тулд хогийн ургамал, хортон шавжийг нугасаар идүүлдэг (үгчлэн орчуулбал: нугасанд идүүлж авна.). Тэрээр 15 жилийн өмнөөс “нугас ашигласан тариалах арга” дээр ажиллаж байна.

(6) (7) өгүүлбэр оюун ухааны бодол зорилгогүйгээр үйлийг хийсэн эзэн биеийн нэг талын гүйцэтгэсэн үйлдэл нь хүлээн авах эзэн биед тус болох утга бүхий өгүүлбэр юм. Дурдсан жишээ өгүүлбэрт байгаа үйлдлийн эзэн бие нь “хөтөч нохой”, “нугас” зэрэг нь амьтны бөгөөд хүлээн авах эзэн бие “Хөтөч нохой”, “нугас” –г ямар нэгэн үйлдэл хийх бодол зорилгыг тулгаагүй боловч (6) өгүүлбэрийн төгсгөлд байгаа “аюулгүй гарав” хэмээх илэрхийллээс үзвэл чухамдаа үйлийн эзэн биеийн хийсэн “Хуцах” үйлдлээс хөгжлийн бэрхшээлтэй эзэн осолд өртөөгүй гэж дүгнэж болно. (7) өгүүлбэрийн хогийн ургамал, хортон шавж идэж тусалдаг “нугас” –ны үйлдэл нь хүлээн авах эзэн биед “нугас ашигласан тариалах арга”-ыг амжилттай хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Иймээс “нугас хортон шавж, хогийн ургамал иддэг” нь хүлээн авах эзэн биеийн хувьд тустай үйлдэл гэж үзэж болно.

3) Хүлээн авах болон үйлийн эзэн биеийн аль аль нь оюун ухааны бодол зорилгогүй эзэн бие бүхий өгүүлбэр

Хүлээн авах болон үйлийн эзэн биеийн аль аль нь оюун ухааны бодол зорилгогүй байх бөгөөд хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биеийн нэг талын үйлдлийн нөлөөнөөс ашиг тус хүртдэг утга бүхий өгүүлбэр байна.

(8) 植物が蜜を昆虫や鳥に与えるかわりに、(昆虫や鳥に) 花粉を運んでもらうというのが受粉共生である。

(山田, 2004)

Ургамал нь балыг ургамал, шавжид өгөхийн оронд, шавж, шувуу нь цэцгийн тоосонцрыг зөөж өгдөг тоос хүртээх үйл явц юм.

(9) なに木々の緑が華やかなのは、昨夜雨に降ってもらったからだ。

(高見・久野, 2002)

Моддын сайхан ногоон өнгө нь өнгөрсөн шөнө бороо орсонтой холбоотой юм. (үгчлэн орчуулбал: бороо орж өгсөн учраас юм.)

Жишээ өгүүлбэр (8) -аас хүлээн авах эзэн бие “ургамал” нь үйлийн эзэн бие “шавж, шувууд” –д тодорхой үйлдэл хийх бодол зорилго тулган хүлээлгэх боломжгүй болохыг харж болно. Гэхдээ “шавж, шувууд цэцгийн тоос зөөх” учраас хүлээн авах эзэн бие “ургамал” тоос хүртэж чадна. Тиймээс цэцгийн тоос тээж яваа шавж, шувуудын зан үйлийн үйлдэл нь хүлээн авах эзэн бие “ургамал”-д үзүүлж буй ач тус гэж дүгнэж болно. Жишээ (9) өгүүлбэрийн эзэн бие “модод” нь мөн

борооны ач ивээлээр ногоорсон гэж үзэж болно.

2. -te morau-гийн тусгүй хэмээх утга, хэрэглээний онцлог

Ямада.Т (山田, 2004,х.154) -te morau-гийн араас *-te ha komaru*, *-te ha ikenai* (-бал хэцүүднэ, -ж болохгүй) хэлбэрийг хэрэглэх нь “-ж өгөх, -ж авах” -ын тус үгүйг илэрхийлдэг хэмээх саналыг дэвшүүлэн, энэхүү хэрэглээг тусгүй байдлын илэрхийлэл гэж нэрлэжээ. Тусгүй байдлын илэрхийллийг мөн идэвхт байдлын хэрэглээ, идэвхгүй байдлын хэрэглээ гэж хувааж болно.

2.1. Идэвхт байдлын хэрэглээ

Хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед тодорхой үйлийг идэвхтэй хийснээр үйлийн эзэн бие хохирсон, тусгүй хэмээх байдал үүснэ.

- (10) 「さあ、ぶん殴ると言ったんだから、殴ってもらおうじゃないか」
(トウエイン (著) [大久保康雄](#) (訳) 『トム・ソーヤーの冒険』)

“За, чи зодно гэсэн болохоор, зодуулья даа”

- (11) 「てめえ、なんで俺にだけ焦げ飯を盛ったのだ。とっくりとわけをきかせてもらおうじゃないか」

立原正秋 『冬の旅』)

“Хөөе, чи яагаад зөвхөн надад түлэнхий будаа аягалдаг билээ. Тодорхой шалтгааныг чинь сонсож авъя даа.”

(10) өгүүлбэрт хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биеийн хэлсэн “зодох” хэмээх үгээс шалтгаалж “Тэгвэл зодуулж авъя” гэж хэлж байна. Хэдийгээр хүлээн авах эзэн бие үйлийн эзэн биед “ирээд зод” хэмээх үйлийг гүйцэтгүүлэх санаа бодол байгаа боловч үйлийн эзэн биеийн “зодох” үйлдэл нь хүлээн авах эзэн биед тус өгөхгүй, харин хор учруулна гэж дүгнэж болно.

(11) өгүүлбэрийн хүлээн авах эзэн бие үйлийн эзэн биед “Өөрт нь түлэнхий будаагаар үйлчлэх болсон шалтгаанаа тайлбарла” хэмээхэд үйлийн эзэн бие “шалтгааныг тайлбарлах” хэдий ч үйлдэл нь хүлээн авах эзэн биед тустай мэт сэтгэгдэл төрүүлэхгүй, харин ч үйлийн эзэн биед сэтгэл дундуур байгааг илэрхийлдэг байна. Хэдийгээр (10) (11) өгүүлбэрт *moratte ha komaru*, *moratte ha ikenai* (-бал⁴ хэцүүднэ, -ж болохгүй) гэх мэт хохирол, тусгүй байдлыг шууд илэрхийлсэн хэлбэр байхгүй боловч, тусгүй байдлыг нь өгүүлбэрийн хам сэдвээс дүгнэн ойлгож болно.

2.2 Идэвхгүй байдлын хэрэглээ

Хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биеийн нэг талын нөлөөллийн улмаас түүний гүйцэтгэсэн тодорхой үйлийг хүлээн авч хохирол амсах, тусгүй байдалтай хэмээх утга бүхий өгүүлбэр үүснэ.

- (12) しかし、まちがってもらってはいけない。(山田, 2004)

Гэхдээ алдаа гаргаж болохгүй! (үгчлэн орчуулбал: Гэхдээ алдаа гаргаж өгч болохгүй.)

- (13) 「白を切つてもらってはこまる。先鋒は明智殿ではないか。わしを先鋒にやってくれ」
(司馬遼太郎 『国盗り物語』)

Андуурвал дэмий шүү! (үгчлэн орчуулбал: андуурч өгөх нь хэцүүднэ.) Тэргүүнд яваа нь Акечи хаан биш гэж үү? Намайг тэргүүнд нь явуул.

(12) (13) өгүүлбэрийн хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед тодорхой үйлдэл хийх бодол санаа зорилгогүй байгаа хэрэглээ юм. Иймээс өгүүлбэрийн “困る/ komaru хэцүүдэх”, “いけなさい/ ikenai болохгүй” үйлдлийн эзэн биеийн үйл нь хүлээн авах эзэн биед хохирол, ашиг тусгүй байдлыг учруулдаг гэж дүгнэж болно.

Жишээ өгүүлбэр (12) -ын хүлээн авах эзэн бие нь үйлдлийн эзэн биед “алдаа гаргах” бодол санаа байхгүй. Харин үйлдлийн эзэн бие “алдаа гаргах” нь хүлээн авах эзэн биед таагүй байдлыг авчирсантай холбоотой байна. Жишээ өгүүлбэр (13) -ын хүлээн авах эзэн бие нь үйлдлийн эзэн биед “андуурсан мэт дүр эсгэх” -ийг хүсээгүй. Харин эсрэгээр энэхүү үйлдэл нь хүлээн авах эзэн биед хор нөлөөтэй, эсвэл тусгүй байна.

Тусгүй байдлын илэрхийлэлд -te morau -гийн араас ихэвчлэн “komaru (困る хэцүүдэх), meiwakuda (迷惑だ төвөг болох, яршигтай), tamaranai (たまらない тэвчихийн аргагүй)” гэх мэт тухайн хүлээн авах эзэн биеийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үгс ордог. Иймд эдгээр үгсийн утгын дагуу үйлийн эзэн биеийн хийж буй зан үйлийн үйлдэл нь хүлээн авах эзэн биед хохирол эсвэл, тусгүй байдал үүсгэдэг байна. Хэрэв өгүүлбэрт ийм үг байхгүй бол хам бүтцээс тухайн үйлийг өгөх, авахад тусгүй байдал үүснэ гэж дүгнэж болно.

Дүгнэлт

Бид энэхүү судалгаандаа хэлний материалын сангийн -te morau хэллэгийг 100 орчим өгүүлбэрээс утга давтагдах байдлаар нь 13 өгүүлбэрийг сонгож дүн шинжилгээ хийж дараах онцлогуудыг олж мэдлээ. Үүнд:

Нэгдүгээрт, -te morau нийлмэл үйл өгүүлэхүүнийг тустай болон тусгүй хэмээх утгын илэрхийлэлд хувааж болно. Тустай хэмээх утгын хэллэг нь үйлээс хүртсэн тустай харилцааг илэрхийлэхэд ашиглах ба хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биеийн үйлдлийн үр дүнд тусыг хүртдэг байна. Тусгүй байдлын илэрхийлэл нь үйлийг өгч, авсанаас үүдэлтэй хор хөнөөл, сөрөг харилцааг илэрхийлэхэд гол төлөв хэрэглэгдэж байгаа бөгөөд цаашид энэхүү хэрэглээг үргэлжлүүлэн судлах шаардлагатай хэмээн үзэж байна.

Хоёрдугаарт, тустай болон тусгүй байдлын хэллэгийн аль алины хүлээн авах эзэн бие нь үйлийн эзэн биед учир шалтгааны талаар хүсэлт гаргаж, хийсэн үйлдлээс ашиг (хохирол) хүртэнэ гэж найдаж буй идэвхт байдлын хэрэглээ, мөн хүлээн авах эзэн бие нь үйлдлийн эзэн биеийн нэг талын үйлдлийн үр дүнгийн нөлөөгөөр түүнээс үр өгөөж болон хохирол хүртэх идэвхгүй байдлын хэрэглээг агуулдаг байна. Бидний дүн шинжилгээ хийсэн өгүүлбэрт идэвхт байдлын хэрэглээнд хүлээн авах эзэн бие нь оюун ухаант бодол зорилгогүй амьтан, ургамлын жишээ ажиглагдаагүй. Үүний шалтгаан нь амьтан, ургамал нь үйлийг идэвхтэй дэмжих боломжгүйд оршино хэмээн үзлээ.

Өмнөх судалгаанаас үзэхэд -te morau хэллэгийн утгын үүрэг нь нэлээд өргөн хүрээнд тусгүй байдлаар хэрэглэгддэг нь тодорхой байна. Гэвч сурах бичгүүдэд ерөнхийдөө тустай байдлын илэрхийллийн хэрэглээг дурдаж, тусгүй байдлын илэрхийллийг бараг дурддаггүй байна. Түүгээр ч барахгүй сурах бичигт -te morau хэллэгийн идэвхт байдал, идэвхгүй байдлыг тун бага тайлбарласан байна. Үүнээс үүдэн суралцагчид -te morau хэллэгийг буруугаар хэрэглэх нь ихээхэн ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь “-ж өгөх”, “-ж авах” үйлийн утгыг сурахад хүндрэл үүсгэх магадлал их байдаг байна. Иймээс судлаачийн зүгээс өгөх, авах утга илэрхийлэх энэхүү хэллэгийг заахдаа зөвхөн хэл зүйн бүтэц, үүрэг, хэлний хэлбэрт анхаарлаа хандуулахаас гадна, тустай болон тусгүй байдал, идэвхт болон идэвхгүй байдал зэрэг хэрэглээний үүргийг нь анхаарч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

The usage characteristics of the Japanese ‘giving and receiving’ auxiliary verb -te morau

Gao wulan

Ph.D student, Mongolian National Education of University, Ulaanbaatar, Mongolia

Minzu College, Hohhot, China

Naidan Bayarmaa

Department of Oriental Language, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In the expression of Japanese giving and receiving, "te morau" is characterized by wide application, complex and varied usage, and changes in grammatical functions according to different contexts, etc. and often becomes one of the difficulties for Chinese, Japanese learners. Taking "te morau" sentence as the research object, this paper analyzes the example sentences extracted from the corpus sorts out its usage from the aspect of causative and reactive voice, the benefactive and non-benefactive construction, and analyzes its grammatical function. Through the investigation and analysis of this paper, it is found that the usage of "te morau" sentence can be divided into two categories, namely, benefactive expression and non-benefactive expression, both of which have causative and passive grammatical functions. In the extracted example sentences, the causative usage of the receiving subject as the heartless object is not observed, the reason is that the nonliving thing cannot actively promote the occurrence of the action. Non-benefactive usage of the receiving subject and the subject of action is limited to a character and don't include nonliving things. This paper has a certain enlightening effect to Japanese learners, and can be of value to Japanese teaching.

Key words: semantic function, benefactive, non-benefactive, causative, passive

Ном зүй

大江三郎. (1975). 日英語の比較研究—主観性をめぐって. 南雲堂. (Saburo Oe. (1975). Comparative study of Japanese and English: Concerning subjectivity. Nanundo)

高見健一・久野暉. (2002). 日英語の自動詞構文：生成文法分析の批判と機能的分析. 研究社. (Kenichi Takami and Susumu Kuno. (2002). Intransitive constructions in Japanese and English: Criticism and functional analysis of generative grammatical analysis. Kenkyusha.)

山本裕子. (2003). 授受補助動詞の対人的機能について. 名古屋女子大学紀要, 49, 269-283. (Hiroko Yamamoto. (2003). On the interpersonal functions of giving and receiving auxiliary verbs. Bulletin of Nagoya Women's University, 49, 269-283.)

山田敏弘. (2004). 日本語のベネファクティブ：「てやる」「てくれる」「てもらう」の文法. 明治書院. (Toshihiro Yamada. (2004). Japanese Benefactor: Grammar of “-te yaru”, “-te kureru”, and “-te morau”. Meiji Shoin.)

松下大三郎. (1930). 改撰標準日本文法. 中文館書店. (Daizaburo Matsushita. (1930). Revised Standard Japanese Grammar. Chubunkan Shoten.)

益岡隆志. (2001). 日本語における授受動詞と恩恵性. 言語(特集「授受」の言語学), 30(5), 26-32.
(Takashi Masuoka. (2001). Verbs of giving and receiving and beneficence in Japanese. Language (Special feature on the linguistics of giving and receiving), 30(5), 26-32.)

鈴木重幸. (1972). 日本語文法・形態論. むぎ書房. (Shigeyuki Suzuki. (1972). Japanese grammar and morphology. Mugi Shobo.)

“CD-ROM-ban Shinchō bunko no 100-satsu”(『CD-ROM版新潮文庫の100冊』)

“CD-Mainichishinbun dēta-ban”(『CD-毎日新聞データ版』)